



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

НАЛАЙХ ДЦС" ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
М.ӨСӨХБАЯР ТАНАА

2014.04.30

№ 04/43 ЧАТ-САТ/2014/46/СТН/ТА/ТН/ӨЧ

Өр авлага барагдуулах тухай

"Налайх ДЦС" ТӨХК-ийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд хийсэн аудитаар Налайх дүүргийн шүүхийн 2013 оны 07 сарын 03-ны өдрийн 186 тоот шийдвэрээр "Чандмань Налайх" НӨҮГ-т 235.5 сая төгрөг төлөхөөр шийдвэрлэснийг данс бүртгэлд тусгаагүй зөрчил илэрсэн бөгөөд энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т "санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т "Аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх.", Монгол улсын ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 2.1.1-д ".....алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ НЬ:

1. "Налайх ДЦС" ТӨХК нь "Чандмань налайх" НӨҮГ-т өгөх 235.5 сая төгрөгийг өглөгөөр бүртгэж, төлөхөөр санхүүгийн тайланд тусгах
2. "Чандмань налайх" НӨҮГ-тай хийсэн гэрээний дагуу үзүүлсэн үйлчилгээг баримтаар нотолж шүүхээр шийдвэрлүүлэх

Аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2014 оны 5 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг "Налайх ДЦС" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал М.Өсөхбаяр нягтлан бодогч Б.Доржмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:

Шинжээч Н.Нямдаваа

УХА0122